

**УСУГ-ААС УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ТӨВЛӨРСӨН  
СИСТЕМД ХЭРЭГЛЭГЧИЙГ ХОЛБОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ  
ОЛГОХОД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

**Хэрэглэгч та: Хуучин барилга болон шинээр барилга барих гэж байгаа бол дараахь материалыг бүрдүүлнэ.**



- Иргэн бол **өргөдөл**, иргэний үнэмлэхний хуулбар, Аж ахуйн нэгж бол **албан бичиг**
- Газрын гэрчилгээ, кадастрын зураг /эзэмших гэрчилгээ бол нь гэрээний хамт/
- **Архитектур төлөвлөлтийн даалгавар, хавсралтын хамт /НХТЕТГ-аас авах/**
- **Барилгын эскиз зураг /НХТЕТГ-аас батлагдсан эхний 3-н нүүр/**



● **Дулааны техникийн нөхцөл /Шаардлагатай үед/**

- **ОСНААУГ-ын тодруулга /Тухайн барилга нь орон сууцны хороолол дотор байрласан бол/**
- **Нэмэлт баримт – 3-аас дээш блок барилга** барьж буй иргэн, аж ахуйн нэгж нь барилгын төлөвлөлтийн зургийг файлаар болон өнгөтөөр хэвлэж өгөх
- **Нэмэлт баримт – Орон сууцны барилга** бол айлын тоог бичих, барилгын усны хэрэглээг м3/хоногоор тооцож тусгах, холбогдох гар утасны дугаар зэргийг Албан бичиг болон өргөдөлд тусгаж өгөх

**Хэрэглэгч та: Гэр хороололд Амины орон сууц барих гэж байгаа бол дараахь материалыг бүрдүүлнэ.**



- Иргэн бол **өргөдөл**, иргэний үнэмлэхний хуулбар, Аж ахуйн нэгж бол **албан бичиг**
- Газрын гэрчилгээ, кадастрын зураг /эзэмших гэрчилгээ бол нь гэрээний хамт/
- **Нэмэлт баримт – Барилгын усны хэрэглээг м3/хоногоор тооцож тусгах, холбогдох гар утасны дугаарыг Албан бичиг болон өргөдөлд тусгаж өгөх**

● **Нэмэлт баримт – Кадастрын зураг дээр шугамын тодруулга: Шугам ашиглалт засварын алба М.Дашдондог утас:94036679, О.Хашхүү утас:96686944 инженерээр хийлгэсэн байх**

**Хэрэглэгч та: Техникийн нөхцөл сунгуулах бол:**

- Иргэн бол **өргөдөл**, иргэний үнэмлэхний хуулбар, Аж ахуйн нэгж бол **албан бичиг**
- Техникийн нөхцлийн хуулбар
- Кадастрын зураг

## Бүрдүүлсэн материалыг хаана хэнд өгөх вэ?



● Хэрэглэгч хүсэлт гаргаж бүрдүүлсэн материалаа Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд буюу Дүнжингарав худалдааны төв, Мишээл экспо, Драгон, 6 буудлын Оргил худалдааны төвүүдэд байрлах УСУГ-ын ажилтанд өгнө.

● Техникийн нөхцөл олгох комисс батлагдсан хуваарийн дагуу 14 хоногт нэг удаа хуралдах бөгөөд шийдвэрийг УСУГ-ын вебсайт [www.usug.ub.gov.mn](http://www.usug.ub.gov.mn) хаягаар орж харах боломжтой.

● Газрын даргын **2014 оны 11-р сарын 03-ны өдрийн А/298** тоот дугаартай тушаалаар 2013 оны 01-р сарын 01-ээс өмнө **ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөл авсан** боловч одоог хүртэл барилга байгууламж нь баригдаагүй, шугам сүлжээнд техникийн нөхцлийн дагуу холбогдоогүй байгаа **нийт хэрэглэгчдийн техникийн нөхцөл хүчингүй** болсон тул уг хэрэглэгчид техникийн нөхцөл хүссэн материалыг **шинээр авахаар** бүрдүүлж өгнө үү.

● Газрын даргын **2014 оны 11-р сарын 03-ны өдрийн А/299** тоот дугаартай тушаалын хавсралтанд заасны дагуу үнэ тарифаар техникийн нөхцлийн төлбөрийг төлсний дараа техникийн нөхцөл болон сунгалтыг хүлээлгэн өгнө.

д/д	Холболт хийх шугам	Үнэ,төг
1	Төвийн шугамнаас шинээр техникийн нөхцөл олгох	165000
2	Гэр хорооллын шугамнаас техникийн нөхцөл олгох	55000
3	Төвийн шугамнаас олгогдсон техникийн нөхцлийг сунгах /1 жилийн хугацаанд хүчинтэй/	82500
4	Гэр хорооллын шугамнаас олгогдсон техникийн нөхцлийг сунгах /1 жилийн хугацаанд хүчинтэй/	27500

Техникийн нөхцлийн үнийг **Хас банкны 5000075928** тоот дансанд тушаана.

Өрөөний №: Өргөтгөлийн **207** тоот Утас: 70157018-129

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР Ц.ЦЭРЭНДУЛАМ утас: 99006200

